

Элсэлтийн бодлого 2024-2025

1. Зорилго

- Америк дунд Сургууль нь Англи хэлтэй орчинд олон улсын стандартад нийцсэн боловсрол олгодог боловсролын байгууллага юм.
- Америк дунд сургууль нь эцэг эх болон сурагчийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэгээр нь үл ялгаварлан жигд хандана.
- Америк дунд сургууль нь сурагч бүрийг өөрийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, сурлага, сахилга бат, нийгэмшил, соёлын талаар өсөн дэвжих боломжийг олгох тэнцвэртэй, нэгдмэл сурах орчинг бүрдүүлэхийг зорино.

2. Элсэлтийн бодлого, практик

- Сургалт хариуцсан захирал, Дунд сургууль хариуцсан координатор сурагчийг элсүүлэх шийдвэрийг гаргана.
- Монгол хэл, гадаад хэлнээс бусад бүх хичээл Англи хэл дээр явагдана.
- Нэг анги дээд тал нь 24 сурагчтай байна.
- Сурагч нь анги алгасан суралцах боломжгүй ба сурагчийг элсүүлэх шийдвэрийг гаргахад тухайн хүүхдийн насны шаардлага хангасан байдал, өмнөх сургуульд сурч байсан сурлагын дүн, элсэлтийн шалгалтын дүн тус бүр дээр үндэслэн шийдвэрлэнэ.
- УАС-д одоогийн сурагчид дараагийн хичээлийн жилд дэвшин суралцахад суудлын баталгааны төлбөрийг сургуулиас заасан хугацаанд төлснөөр элсэн орох ангийн жагсаалтад орно. Хэрэв дараагийн хичээлийн жилийн суудлын баталгааны төлбөр болон эцэг эхтэй хийх гэрээнд гарын үсэг зураагүй тохиолдолд тухайн сурагчийн суудлыг хадгалж үлдэхгүй. Мөн одоо сурч буй сурагчийн төрсөн эгч ах дүүсийг элсэлтийн шаардлагад нийцвэл элсэлтийн бүртгэлийг эрт хийж болно.
- Элсэлтийн багц материалыг нэг бүрчлэн бүрдүүлсний дараа тухайн сурагчийг бүртгэн авна. Хэрэв аль нэг материал дутуу бүрдүүлсэн бол бүртгэл хүчингүй болно.
- Элсэлтийн анкетийг ямар нэг байдлаар буруу бөглөсөн тохиолдолд тухайн хүүхдийг бүртгэж авахгүй.
- Шаардлагатай бүх төлбөр хийгдсэний дараа тухайн хүүхдийг хичээлд суулгана.
- Эцэг эхчүүдийн зүгээс анги хуваарилалтын талаар хүсэлт хүлээн авахгүй болно.
- Нэг гэр бүлийн хүүхдүүд Бага, Дунд, Ахлах сургуульд тус тус элсэн орж байгаа тохиолдолд элсүүлэх эцсийн шийдвэрийг Бага сургууль, Дунд, Ахлах сургуулийн Сургалт хариуцсан захирлууд хамтран гаргана.
- Сурагч хичээлд хамрагдаж эхэлсний дараа сургуулийн шалгуур үзүүлэлтүүдэд тэнцэхгүй болох нь сургуулийн захиргаагаар тогтоогдвол тухайн сурагчийг сургуулиас гаргана. Хичээлд суугаагүй өдрийн сургалтын төлбөрийг эргүүлэн олгоно.

3. Элсэлтийн үйл явц

- Элсэлтийн маягтыг бүрэн бөглөж, холбогдох материалыг бүрдүүлсний дараа сургалтын албанд хүлээлгэн өгнө.

- Бүртгэлийн хураамжийг төлж материал бүрэн гүйцэд бүрдсэн бол сургалтын албанаас эцэг эх/асран хамгаалагчтай холбогдож, шалгалт авах хуваарийг мэдэгдэнэ.
- Хамрагдсан сургуулиас нь үл хамааран сурагч бүрээс англи хэлний түвшин тогтоох элсэлтийн шалгалт авна.
- Элсэлтийн явцад ямар нэгэн зөрчил гарсан тохиолдолд Сургалт хариуцсан захирал эсвэл Дунд сургуулийг хариуцсан координатор тухайн сурагчтай элсэлтийн ярилцлага хийнэ. Тус ярилцлага нь хуваарьтай байх бөгөөд шинээр элсэж буй сурагч заавал оролцоно.
- Элсүүлэх шийдвэрийг тухайн хүүхдийн насны шаардлага хангасан байдал, өмнөх сургуульд сурч байсан сурлагын дүн, ярилцлага болон элсэлтийн шалгалтын дүн тус бүр дээр үндэслэн шийдвэрлэнэ.
- Сургуульд элссэний дараа Сургалт хариуцсан захирал ба Дунд сургууль хариуцсан захирал элсэлтийг баталгаажуулж, зөвшөөрлийн маягтад гарын үсэг зурах бөгөөд шинэ сурагчийн орох анги, бахархлын багт хувиарлана.
- Сургуулийн захиргааны зөвшөөрлийн дагуу сургалтын албанаас сурагчийн эцэг эхтэй холбогдож, сурагчийг элсүүлэх талаарх шийдвэрийг элсэлтийн шалгалт авснаас хойш 1-3 ажлын өдрийн дотор мэдэгдэнэ
- Тухайн сурагчийг элсүүлэх шийдвэр гарсны дараа сургалтын алба санхүүгийн албад мэдэгдэж, санхүүгийн алба сургалтын төлбөрийн нэхэмжлэхийг эцэг эх, асран хамгаалагчид руу явуулна.
- Сургалт хариуцсан ажилтан хуваарилагдсан ангийн багш болон бусад багш нарт шинээр элсэн орж буй сурагчийн мэдээллийг өгнө.

4. Хэлний шаардлага

- Сурагч амжилттай суралцахын тулд сургуулиас тавьж буй англи хэлний түвшингийн шаардлагыг хангасан байна.
- Англи хэлний нэмэлт туслалцаа шаардлагатай байгаа сурагчдыг Англи хэлний нэмэлт хөтөлбөрт хамруулна.

5. Элсэлтийн шалгалтын бодлого

- Шинээр элсэн орж буй сурагчдаас Англи хэл, Математик болон бусад шаардлагатай хичээлээр элсэлтийн шалгалт авна.
- Англи хэл тухайн хүүхдийн эх хэл, хоёрдогч хэл байх болон тухайн хүүхэд англи хэлтэй орчинд хэдэн жил сурснаас үл хамаарна сурагч бүрээс Англи хэлний түвшин тогтоох шалгалт авна.

6. Насны хязгаар болон хичээлийн жилийн дундаас элсэн орох

- Шинээр элсэж буй сурагч зөвхөн өөрийн насны ангиллын шаардлагыг хангаж, анги, сурлагын дүн болон элсэлтийн шалгалтын дүн сургуулийн шаардлагад нийцсэн тохиолдолд тухайн ангид элсэн орно.
- УАС-д өөр хичээлийн жилийн хуваарьтай (1-р сараас 11-р сар хүртэл) сургуулиас элсэн орсон сурагчид УАС-ын хичээлийн жилийн эхэнд элссэн тохиолдолд одоо сурч буй ангиа үргэлжлүүлэн сурна. Харин УАС-д хичээлийн жилийн дундуур орохыг хүсэж байгаа бол тухайн сурагчийг бүрэн дүүргэсэн ангийн дараагийн анги руу оруулна.
- Семестрийн дундуур шинээр элссэн хүүхэд семестрийн төлбөрийг бүтэн төлнө.

7. Тусгай хэрэгцээт сурагч

- Сургалт Хариуцсан Захирал тусгай хэрэгцээт сурагчийн хэрэгцээг сургууль хангаж чадна гэж тогтоосны дараа тухайн сурагчийг шинээр элсүүлэн авна.

- Сургалт хариуцсан захирал сургуулийн тухайн хүүхдийн тусгай хэрэгцээг хангах боломжгүйг тогтоовол элсүүлэн авахаас татгалзана.

8. Хүлээлгийн жагсаалт

- Элсэлтийн шаардлага хангасан боловч тухайн ангид орон тоо байхгүй тохиолдолд сурагчийг хүлээлгийн жагсаалтад авна.
- Тохирох ангид орон тоо байхгүй үед дээд, доод ангид оруулах боломжгүй.
- Материал бүрдүүлсэн сурагчийг хүлээлгийн жагсаалтад бүртгэн авч эцэг эхэд мэдэгдэнэ.
- Хүлээлгэнд байгаа сурагчийг өргөдлөө өгсөн дарааллын дагуу элсүүлнэ.

9. Туршилтын хугацаа

- Шаардлагатай тохиолдолд сурагчид тухайн хичээлийн жилийн туршид туршилтын хугацаа өгнө. Туршилтын хугацаанд тухайн сурагч сурлага, хэлний түвшин, сахилга батын хувьд хоцрогдож байгаа болон сургалт харилцан үр өгөөжтэй байгаа эсэхийг харна.

10. 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтын төлбөр төлөх хугацаа

- 1-р семестрийн төлбөрийг 2024 оны 8-р сарын 14-ны дотор төлнө.
- 2-р семестрийн төлбөрийг 2024 оны 12-р сарын 04-ний дотор төлнө.
- Семестр эхэлснээс хойш 10 хоногийн дотор төлбөр нь төлөгдөөгүй сурагчийг сургуулиас хасах арга хэмжээ авна. Хасагдсан сурагч дараагийн хичээлийн жилд дахин элсэх хүсэлт гаргаж болно.

11. Шинээр элсэн орж байгаа сурагчийн насанд тавих шаардлага

Анги	Төрсөн он сар:
6	Oct 2012, Nov 2012, Dec 2012, Jan 2013, Feb 2013, March 2013, April 2013, May 2013, June 2013, July 2013, Aug 2013, September 30, 2013
7	Oct 2011, Nov 2011, Dec 2011, Jan 2012, Feb 2012, March 2012, April 2012, May 2012, June 2012, July 2012, Aug 2012, September 30, 2012
8	Oct 2010, Nov 2010, Dec 2010, Jan 2011, Feb 2011, March 2011, April 2011, May 2011, June 2011, July 2011, August 2011, September 30, 2011
9	Oct 2009, Nov 2009, Dec 2009, Jan 2010, Feb 2010, March 2010, April 2010, May 2010, June 2010, July 2010, Aug 2010, September 30, 2010
10	Oct 2008, Nov 2008, Dec 2008, Jan 2009, Feb 2009, March 2009, April 2009, May 2009, June 2009, July 2009, Aug 2009, September 30, 2009
11	Oct 2007, Nov 2007, Dec 2007, Jan 2008, Feb 2008, March 2008, April 2008, May 2008, June 2008, July 2008, Aug 2008, September 30, 2008
12	Oct 2006, Nov 2006, Dec 2006, Jan 2007, Feb 2007, March 2007, April 2007, May 2007, June 2007, July 2007, Aug 2007, September 30, 2007